



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Улаанбаатар хот, 15160, Утас 70191087 Факс: (976) 70191087  
Цахим шуудан: info@police.gov.mn  
Цахим хуудас: www.police.gov.mn

2023.11.29 № 03/345  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Эрсдэлийн үнэлгээний тайлан хүргүүлэх  
тухай

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны эрсдэлийн үнэлгээний тайланг хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 9 хуудастай.



Цагдаагийн ерөнхий газар  
Цагдаагийн ерөнхий газар  
Дэд дарга  
Төмөрбат Ганзориг  
2023.11.29 11:49

Хууль зүй, дотоод хэргийн  
Яамны хяналт шинжилгээ,  
үнэлгээ, дотоод аудитын  
Газрын дарга Б.Мөнхбаяр  
Танаа

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР**

**ТАНИЛЦУУЛГА**

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны  
эрсдэлийн үнэлгээний талаар”

2023 оны 11 дүгээр  
сарын 28-ны өдөр

№ 3/204

Улаанбаатар  
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 эрсдэлийн үнэлгээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/120 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”, Стандарт, хэмжил зүйн газраас 2020 онд баталсан “Эрсдэлийн менежментийн тогтолцоо /MNS ISO31000:2020 стандарт”, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалаар батлагдсан “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам (код-137)”-ыг удирдлага болгон цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас эрсдэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу тодорхойлсон эрсдэлийн үнэлгээний тайланд тооцох аргачлалын дагуу гаргаж ирүүлсэн тайланд үндэслэн хийлээ.

**Эрсдэлийн үнэлгээний зорилго:** Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны зорилго, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, учирч болзошгүй эрсдэлийн талаар удирдлагад мэдээлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээг хийсэн.

**Эрсдэлийн үнэлгээний ажлын хүрээ:** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нийт төсөвт 55 нэгжээс ирүүлсэн эрсдэлийн үнэлгээ, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эрсдэлийн мэдээллийн (2014-2023 он) цахим сан, 2024 онд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тодорхойлж, үнэлэх байдлаар эрсдэлийн үнэлгээг хийв.

**Нэг. Эрсдэлийн үнэлгээний талаар:**

1.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг үнэн зөв, бодитой, алба хаагч бүрийн оролцоог хангасан байдлаар тодорхойлох, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх, хариу арга хэмжээг оновчтой төлөвлөх, үр дүнг тооцох, эрсдэлийн удирдлагыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үйл явцыг Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж байна.

1.2.Албад, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүрт тухайн байгууллагын даргаар ахлуулсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багууд ажилладаг бөгөөд тухайн нэгжийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, 18 онооноос дээш үнэлгээтэй эрсдэлийг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэлийн хамт Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлж хэвшсэн.

Тухайн нэгжийн орон тооны бус багийн гишүүд нь өөрсдийн тодорхойлсон эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг төлөвлөж, дараа жилийн эрсдэлийн менежментийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлт, үр дүнг хагас, бүтэн жилээр тооцон ажиллаж байна.



1.3.Дотоод хяналт-аюулгүй байдлын газар нь Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын нийт төсөвт 55 нэгжээс тодорхойлж ирүүлсэн 558 эрсдэлд хийсэн үнэлгээг хянан үзэж, цагдаа, дотоодын цэргийн байгууллагын эрсдэлийн мэдээллийн (2014-2023 он) цахим сантай тулгалт хийж, 25 оноотой 12 эрсдэлийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд мэдээлж байна.

1.4.Тус газраас 2023 онд тодорхойлсон эрсдэлийг бууруулах чиглэлээр цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний үр дүнг тооцож, 2024 онд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилсан байдлаар тодорхойлон үнэлж, хариу арга хэмжээний саналын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж байна. (Хавсралт №1)

### **Хоёр. Дүгнэлт:**

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажил, арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцож ажилласан. Үүнд;

2.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2014-2023 онуудад нийт 13 удаа эрсдэлээ тодорхойлж, үнэлгээ хийн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлж, үр дүнг тооцуулж ажилласан.

2.2.Эрсдэлийн удирдлагыг бодитой хэрэгжүүлж, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд эрх зүйн орчин бүрдсэн, орон тооны бус багийн үйл ажиллагаа жигдэрсэн, алба хаагчдын эрсдэлийн талаарх ойлголт дээшилсэн, эрсдэлийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу хийж хэвшсэн, хагас, бүтэн жилээр эрсдэлийн үнэлгээний байдалд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч байна.

2.3.Тус газраас 2023 онд “Дотоод аудитын ойлголт”, “Эрсдэлийн удирдлага”, “Шилэн дансны хуулийн хэрэгжилт” сэдвээр цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 22 нэгжид 44 цагийн сургалтыг зохион байгуулж, 288 алба хаагчийг хамруулсан.

2.4.Бүгд Найрамдах Сингапур улсын Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын академид 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 24-ний өдөр хүртэлх хугацаанд 19 алба хаагчийг сургалтад хамруулж, гэрчилгээ олгуулсан.

2.5.Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ын дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдалд явцын эрсдэлийн үнэлгээ хийсэн тайланг 2023 оны 6/4142 дугаартай албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.

Цагдаагийн байгууллагын чиг үүрэгт хамаарах 79 шалгуур үзүүлэлт (чиг үүрэгт хамаарахгүй 19)-ээр шилэн индексийг тооцоход өнөөдрийн байдлаар 100 хувьтай байна.

2.6.Тус газраас 2018-2023 онд хэрэгжүүлсэн дотоод аудитын болон эрсдэлийн үнэлгээний тайлангийн эмхэтгэлийг PDF файл болгож, Цагдаагийн ерөнхий газрын [www.police.gov.mn](http://www.police.gov.mn) цахим хуудсанд байршуулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан.

2.7.Эрсдэлээ тодорхойлж, үнэлж ирүүлсэн 55 байгууллагын эрсдэлийн үнэлгээний тайланг хянаж үзэхэд учирч болзошгүй онцлог эрсдэлийг тооцон үнэлж, эрсдэлүүдийг тодорхойлж байгаа боловч эрсдэл гарсан тохиолдол бүрийг үнэн зөв бүртгэх, эрсдэлийн түвшнийг тодорхой тогтоох, ач холбогдлын зэрэглэлийн дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, үр дүнд хяналт-шинжилгээ хийх, дахин эрсдэлээ тооцож, хэлбэлзлийг өмнөх жилүүдтэй харьцуулж хянахад чиглэсэн эрсдэлийн бүртгэлийг үнэн зөв, бодитой хөтөлж хэвшүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэж дүгнэсэн.

2.8.Цагдаагийн төв байгууллагаас алба хаагчдын эрх ашгийг хамгаалах, эдийн засгийн болон нийгмийн баталгааг хангах, ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх, бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сул орон тоог нөхөн хангах чиглэлээр тодорхой үе



шаттай, үр нөлөөтэй ажил, арга хэмжээг хэрэгжүүлж ажилласны үр дүнд өмнөх жилийн эрсдэлүүд тодорхой түвшинд буурсан гэж дүгнэж байна.

2.9.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2024 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээгээр "Их" түвшинд үнэлэгдсэн 12 эрсдэлийг бууруулах арга хэмжээний саналын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, мэдээлэх нь зүйтэй гэж дүгнэлээ.

#### Гурав. Санал:

4.1.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны эрсдэлийн үнэлгээний тайланг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (ДХАБГ);

4.2.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад 2024 онд учирч болох эрсдэлийн урьдчилсан үнэлгээгээр "Их" түвшинд үнэлэгдсэн 12 эрсдэлийг бууруулах арга хэмжээг "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2024 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах (ДХАБГ);

4.3.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагууд өөрсдийн 2023 оны эрсдэлийн үнэлгээндээ үндэслэн эрсдэлийг бууруулах хариу арга хэмжээг тухайн байгууллагын 2024 оны эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хагас, бүтэн жилээр биелэлт, үр дүнг тооцох (Албад, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага);

4.4.Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх орон тооны бус багуудад ажиллаж байгаа мэргэшсэн алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, үр дүнгийн урамшуулал олгох, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллах (Албад, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага);

4.5.Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дарга, захирагч нар өдөр тутмын үйл ажиллагаандаа эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүнг тооцох 8 шалгуур үзүүлэлтийг хангах, өөрсдөө эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, боловсролоо бие даан дээшлүүлэх, эрсдэлд суурилсан удирдлагын шийдвэр гаргахад анхаарч ажиллах шаардлагатай байгааг Танд илтгэн танилцуулъя.

ТАНИЛЦСАН:

ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Т.ГАНЗОРИГ

Удирдлагын шийдвэр: \_\_\_\_\_

ХЯНАСАН:

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.МАНЛАЙБААТАР

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН ЧИГЛЭЛИЙН АХДАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА М.АЗЖАРГАЛ

Хавсралт №1

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 эрсдэлийн үнэлгээ

2023.11.28

Улаанбаатар хот

№	Тодорхойлсон эрсдэл	Эрсдэлийн ангилал	Магадлал	Нөлөөлөл	Эрсдэлийн үнэлгээ	Хариу арга хэмжээний санал (Тайлбар)
1	Алба хаагчдын ээлжийн амралтыг хуулиар тогтоосон хугацаагаар олгодоггүй, жигд бус амралтыг эдлүүлж байгаа нь алба хаагчдын сэтгэл зүйн байдалд сөрөг нөлөө үзүүлэх, тэдний гэр бүлдээ зарцуулах цаг хугацааг багасгах, ажлын гүйцэтгэл, үр дүнд сөргөөр нөлөөлөх (Албад, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага)	Б1	5	5	25	Цагдаагийн албаны тухай хуулийн 90 дүгээр зүйлийн 90.2. "Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий цагдаагийн алба хаагчид алба хаасан 2 жил тутам ажлын 3 өдрийн ... нэмэгдэл амралт олгоно", 90.3 "Ажлын зайлшгүй шаардлагаар нэмэгдэл амралтаа биеэр бүрэн эдэлж чадаагүй цагдаагийн алба хаагчид түүний зөвшөөрснөөр хоногт ногдох цалинг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшил олгоно" гэсэн заалтын хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх (ЗУГ, ХНХ, ХХ, САТА).
2	Алба хаагчдын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн үр дүн, явцыг хянан баримтжуулах энгэрийн камерын хүрэлцээ хангалтгүй байгаагаас алба хаагчийн үйл ажиллагааг иргэдийн зүгээс буруутгах, үндэслэлгүйгээр олон нийтийн цахим сүлжээгээр гүтгэх, мөн нөгөө талаас алба хаагчдын эрх ашиг зөрчигдөх, тэдний үүрэг гүйцэтгэлийн байдалд	Б2	5	5	25	Алба хаагчдын үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн үр дүн, явцыг хянан баримтжуулах энгэрийн камерын хэрэгцээ шаардлагыг судалж, эргүүлийн офицер, замын цагдаагийн ажилтан, мөрдөгч нарыг эхний ээлжинд бүрэн хангах асуудлыг шийдвэрлүүлэх (НХЖХОНАБХА, ТЦА, МБА, САТА).



	<p>сөргөөр нөлөөлөх (Албад, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага)</p>					
3	<p>Алба хаагчдыг дэвшүүлэн томилохдоо албан хаагчийн мэдлэг, мэргэжил, ажлын туршлага, ур чадвар, чөдөмж, гаргасан амжилт, хувийн болон мэргэжлийн ёс зүйг үндэслэн, албан тушаал эрхлэх шат дарааллаар томилох зарчмыг баримтлаагүйгээс алба хаагчдын албандаа хандах хандлага суларч, цагдаагийн албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах (Албад, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага)</p>	Б3	5	5	25	<p>Цагдаагийн алба хаагчдыг бэлтгэх, сурган дадлагажуулах, чадваржуулах, шударга, зарчимч, ажилдаа өөриймсөг сэтгэлтэй, ёс зүйтэй, харилцааны өндөр ур чадвартай алба хаагч болгон төлөвшүүлэх, хүний нөөцийн бодлогод мерит зарчмыг тууштай баримтлах талаар Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлт, үр дүнг тогтмол тооцох (ХНХ, ТЗБХ).</p>
4	<p>Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд алба хаагч руу чиглэсэн дайралт хийх, сүрдүүлэх, заналхийлэх, худал мэдээлэл тараах алба хаагчдын гэр бүл, ойр дотны хүмүүст нөлөөлөхийг оролдох, сүрдүүлэх, дарамтлах тухайн хүмүүсийн мэдээллээр алба хаагчдыг барьцаалах (Албад, нэгж,</p>	Б4	5	5	25	<p>Алба хаагчид цахим орчинд хувийн мэдээллээ оруулахгүй байх, албан үүргээ гүйцэтгэх явцад аливаа ашиг, сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд шууд удирдах албан тушаалтанд даруй мэдэгдэх, Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тасагт нэн даруй хүсэлт гаргаж байхад анхаарч ажиллах (ХХ, УСГ, ДХАБГ).</p>

5	нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага)	Б5	5	5	25	Хуулийн хэлтсээс зохион байгуулсан “Орон нутгийн цагдаагийн газар, хэлтсүүдийн сумын хэсгийн төлөөлөгч, экологийн байцаагч, цагдаа нарын албан үүрэг гүйцэтгэж байгаа ажлын байр, амьдрах орон сууцны орчин нөхцөлийн судалгаа”-ны дүнг 2023 оны 5г/4267 дугаартай албан бичгээр Санхүү, ар талын газарт хүргүүлсэн байна. Иймд уг судалгааны дүнг үндэслэн зохион байгуулалтын арга хэмжээг авч, үр дүнг тооцох (САТА, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага)
6	Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх саатуулах төвийн дулааны шугамын хоолой болон цахилгааны монтажийг шинэчлээгүйгээс байгууллагын хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэх (НЦУГ)	Б6	5	5	25	Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Эрүүлжүүлэх саатуулах төвийн дулааны шугамын хоолой болон цахилгааны монтажийг шинэчлэх зардлын тооцоог нарийвчлан бодитой гаргаж, Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга болон Санхүү, ар талын газрын дарга нарт танилцуулж, шийдвэрлүүлэх (НЦУГ, САТА, ЭСТ).
7	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтарсан стратеги, команд штабын сургалтад хамрагдах, зохион байгуулахад шаардагдах, техник хэрэгсэл, санхүүгийн төсөв (НХЖХОНАБХА)	Б7	5	5	25	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтарсан стратеги, команд штабын сургалт зохион байгуулахад шаардагдах, техник хэрэгсэл, санхүүгийн төсөв тооцооллыг нарийвчлан гаргаж, Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга болон Санхүү, ар талын газрын дарга нарт танилцуулж, шийдвэрлүүлэх (НЦУГ, САТА, НХЖХОНАБХА)



8	Цагдаагийн байгууллагын радио холбооны хэвийн үйл ажиллагаа алдагдах, нууцлал, аюулгүй байдал хангагдахгүй байх (МДШШУА)	Б8	5	5	25	Хууль зүй, дотоод хэргийн яамнаас төслийг АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Моторола сольюшн” компанитай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөж, АНУ-ын Засгийн газраас 2022 онд 5.0, энэ онд 7.0, нийт 12.0 сая ам.долларын санхүүжилт шийдвэрлэгдсэн. АНУ-ын Засгийн газраас “Моторола сольюшн” компанитай гэрээ байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа бөгөөд энэ оны 10 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулагдсан Дэд сайдтай хийсэн цахим хурлын үеэр “Моторола сольюшн” компанийн төслийн зохицуулагч нар энэ ондоо багтааж гэрээг байгуулж, радио, станцын тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр төлөвлөж байгаа талаар мэдэгдсэн байна. (МДШШУА, САТА)
9	“Windows 7, 8” үйлдлийн системтэй, ашиглалтын хугацаа дууссан, шаардлага хангахгүй компьютерыг үйл ажиллагаанд ашиглаж байгаа нь кибер халдлагад өртөх, мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдал алдагдах (МДШШУА)	Б9	5	5	25	2023 оны эхний 10 сарын байдлаар сүлжээнээс гадагшаа чиглэсэн 1 сая 128 хориотой хандалт илэрсэн бөгөөд уг хандалтыг хийж буй 96 компьютерыг олж илрүүлэн, 60 компьютерыг үйл ажиллагаанаас тусгаарлах, аюулгүй болгох хариу арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэгдсэн дөмэйн сүлжээнд холбогдсон нийт 5401 компьютерын 909 буюу 16.8 хувь нь Microsoft компаниас үйлдлийн системийн шинэчлэлтийг зогсоосон window 7, 8 үйлдлийн системтэй, ашиглалтын хугацаа дууссан, шаардлага хангахгүй техникийн үзүүлэлттэй байх тул нийт 1200 компьютер, 200 гаруй нотебүүк шаардлагатай судалгааг гаргаж, 2.7 тэрбум, мэдээллийн аюулгүй байдлын дэд бүтцийг шинэчлэх 2.4 тэрбум төгрөгийн тооцоог тус тус гаргаж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. (МДШШУА, САТА)
10	Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үндсэн төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан	Б10	5	5	25	Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн дуудлага, мэдээлэл хүлээн авах сүлжээний ажиллагаа зогсох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банктэй хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй



	<p>тул цагдаагийн байгууллагын дуудлага, мэдээлэл хүлээн авах сүлжээний хэвийн үйл ажиллагаа доголдох (МДШШУА)</p>					<p>тэмцэх төсөл"-ийн хүрээнд 200 сая төгрөгийн санхүүжилтээр сүлжээний 16 ширхэг төхөөрөмжийг худалдан авч, суурилуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.</p> <p>Мөн тусгай дугаарын 101/105, 102, 103 дугаарын яаралтай тусламжийн дуудлага, мэдээлэл хүлээн авах үйл ажиллагааны сүлжээний тоног төхөөрөмж, дуудлага, мэдээлэл хүлээн авах компьютер, үл тасалдах цахилгаан тэжээлийн систем (UPS), мэдээлэл хадгалах төхөөрөмжүүдийн ашиглалтын хугацаа дууссан тул дуудлага, мэдээлэл хүлээн авах тусгай зориулалтын телефон холбооны систем, сүлжээний үндсэн болон зангилаа төхөөрөмжийг шинэчлэхэд 592,6 сая, үл тасалдах тэжээлийн систем (UPS)-ийг шинэчлэхэд 170,7 сая, дуудлага, мэдээлэл хүлээн авах компьютерыг шинэчлэхэд 188,1 сая, мэдээлэл хадгалах төхөөрөмжийн шинэчлэлд 399,7 сая, тусгай зориулалтын телефон холбооны систем, программ хангамжийн албан ёсны лиценз сунгуулахад 152,3 сая, нийт 1.5 тэрбум төгрөгийн зардлыг 2024 оны төсөвт тусгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/660 дугаар албан бичгээр хүргүүлсэн. (МДШШУА, САТА)</p>
11	<p>Нийслэлийн мөрдөн байцаах нэгжүүдийн мөрдөгч нарын ажлын ачаалал их, мэргэжлийн ур чадвар дутмаг байгаагаас хэргийн шийдвэрлэлт удаашрах, иргэдийн хууль ёсны эрх ашиг хохирох, мөрдөгч нартай холбоотой гомдлын тоо нэмэгдэх, албаны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх (МБА)</p>	Б11	5	5	25	<p>Нийслэлийн мөрдөн байцаах нэгжүүдийн мөрдөгч нарын ажлын ачааллыг бууруулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр судалгааны дүнд суурилсан зохион байгуулалтын үр дүнтэй ажил, арга хэмжээг хэрэгжүүлж, бодит үр дүнг тооцох (ХНХ, СГАСХ, МБА)</p>

12	Дотоодын цэргийн штаб нь Хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллахад эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхой бус байгаагаас хамтын ажиллагаанд саад учрах (ДЦШ)	А1	5	5	25	Дотоодын цэргийн тухай хуульд Хил хамгаалах байгууллагатай хамтран ажиллах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэх (ДЦШ, ХХ)
----	--	----	---	---	----	--



ЦАГДААГИЙН ӨРӨНХИЙ ГАЗАР